

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/72/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗАА	Захирагчийн Ажлын Алба



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.20 № 01/90
танай _____-ны № _____-т

ХАТГАЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБА ҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.БАТБАЯР
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд байгууллагын нэр дээр бүртгэлтэй 6 газрын гэрчилгээг шинэчлэн гаргуулж суурь үнэлгээ тогтоож нийт 77,768.0 мянган төгрөгөөр төрийн өмчийг нэмэгдүүлэн бусад биет бус хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналтын горим сорил хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны дарга нь тосгоны захирагчтай 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 83.3 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,189,815.00	95,763,935.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,189,815.00	95,763,935.00
354	Хангамжийн материал	62,694,815.00	94,293,935.00
35410	Бичиг хэргийн материал	1,527,400.00	3,107,100.00
35420	Аж ахуйн материал	168,100.00	2,148,020.00
35440	Түлш, шатах тослох материал	26,979,500.00	30,612,000.00
35450	Барилгын засварын материал	2,368,840.00	12,816,340.00
35470	Бусад хангамжийн материал	31,650,975.00	45,610,475.00
35600	Мал амьтад	1,495,000.00	1,470,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,860,612,959.20	1,817,141,770.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,860,612,959.20	1,817,141,770.04
392	Биет хөрөнгө	1,826,473,125.92	1,705,158,936.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,387,558,068.15	1,387,558,068.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-98,800,962.73	-131,261,714.65
39203	Авто-тээврийн хэрэгсэл	238,904,800.00	251,001,851.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-63,710,316.52	-97,500,454.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,943,760.00	107,011,792.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,939,731.41	-67,365,061.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,095,000.00	19,095,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,373,541.92	-7,363,042.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	403,192,163.40	403,192,163.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-103,396,113.05	-159,209,665.29
393	Биет бус хөрөнгө	34,139,833.28	111,982,833.28
39301	Програм хангамж	715,833.28	790,833.28
39303	Бусад биет бус хөрөнгө	33,424,000.00	111,192,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,924,802,774.20	1,912,905,705.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,924,802,774.20	1,912,905,705.04
51	Засгийн газрын хувь оролцоо	1,924,802,774.20	1,912,905,705.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	77,768,000.00
51101	Өмч: - төрийн	00.00	77,768,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,731,325,065.54	1,641,659,996.38
51210	Өмнөх үеийн үр дүн	1,731,325,065.54	1,731,325,065.54
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-89,665,069.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	193,477,708.66	193,477,708.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,924,802,774.20	1,912,905,705.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	557,327,509.00	471,614,983.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,071,140.00	30,080,083.00
120	Нийтлэг татварын бус орлого	82,071,140.00	30,080,083.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,071,140.00	30,080,083.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,071,140.00	30,080,083.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,256,369.00	441,534,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,770,800.00	20,942,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	675,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,400,000.00	9,867,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,848,800.00	10,970,800.00

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	847,000.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	464,485,569.00	420,592,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	464,485,569.00	420,592,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	505,250,850.20	560,855,052.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,250,850.20	560,855,052.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,061,174.78	511,163,039.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,020,174.70	220,807,817.52
210101	Үндсэн цалин	187,941,374.70	166,512,735.52
210102	Нэмэгдэл	00.00	26,607,674.00
210104	Урамшуулал	00.00	22,730,594.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,078,800.00	4,956,814.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,174,500.00	26,623,999.18
210201	Тэтгэврийн даатгал	19,727,500.00	17,966,954.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,111,700.00	2,206,194.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,689,400.00	1,735,835.09
210204	Ажилгүйдлийн даатгал	422,400.42	438,942.09
210205	Эрүүл мэндийн даатгал	4,223,499.58	4,276,073.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,054,948.88	22,247,694.89
210301	Гэрэл, цахилгаан	6,755,828.88	7,958,294.89
210302	Түлш, халаалт	10,016,720.00	13,670,000.00
210303	Цэвэр, бохир ус	282,400.00	619,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,887,423.00	41,951,410.00
210401	Бичиг хэрэг	3,164,450.00	6,214,400.00
210402	Тээвэр, шатахуун	20,042,149.00	23,422,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,432,000.00	3,832,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,533,624.00	6,852,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	715,200.00	1,630,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,202,300.00	25,067,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	98,500.00	2,873,000.00
210604	Урсгал засвар	5,103,800.00	22,194,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	2,602,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	2,602,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,315,861.00	12,295,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,697,061.00	10,040,030.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	412,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,800.00	450,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	143,000.00
210807	Газрын төлбөр	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,405,967.20	159,566,388.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,709,676.00	14,452,116.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	635,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,696,291.20	144,479,272.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,189,675.42	49,692,012.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,765,200.00	11,683,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,564,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,265,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,119,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,424,475.42	38,008,212.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,424,475.42	38,008,212.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	52,076,658.80	-89,240,069.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,678,750.00	425,000.00

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,138,000.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,540,750.00	425,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,678,750.00	-425,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>45,397,908.80</u>	<u>-89,665,069.16</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>475,256,369.00</u>	<u>441,534,900.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>475,256,369.00</u>	<u>441,534,900.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,770,800.00	20,942,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	675,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,400,000.00	9,867,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,848,800.00	10,970,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	847,000.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	464,485,569.00	420,592,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	464,485,569.00	420,592,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>403,391,669.00</u>	<u>434,448,900.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>403,391,669.00</u>	<u>434,448,900.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>348,201,993.58</u>	<u>384,756,887.59</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,020,174.70	220,807,817.52
210101	Үндсэн цалин	187,941,374.70	166,503,219.52
210102	Нэмэгдэл	00.00	26,617,190.00
210104	Урамшуулал	00.00	22,730,594.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,078,800.00	4,956,814.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,174,500.00	26,623,999.18
210201	Тэтгэврийн даатгал	19,727,500.00	17,966,954.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,111,700.00	2,206,193.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,689,400.00	1,735,835.09
210204	Ажилгүйдлийн даатгал	422,400.00	429,358.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,223,500.00	4,285,657.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,019,518.88	21,003,754.89
210301	Гэрэл, цахилгаан	6,755,828.88	7,958,294.89
210302	Түлш, халаалт	16,910,490.00	11,997,500.00
210303	Цэвэр, бохир ус	353,200.00	1,047,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,500,749.00	47,820,250.00
210401	Бичиг хэрэг	3,930,000.00	7,127,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,975,549.00	27,077,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,432,000.00	4,189,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,486,800.00	6,852,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	676,400.00	2,574,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,835,300.00	21,831,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	335,300.00	2,873,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	18,958,050.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	2,602,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	2,602,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,251,751.00	30,499,900.00

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,632,951.00	28,243,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	412,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,800.00	450,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	143,000.00
210807	Газрын төлбөр	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,400,000.00	13,568,116.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,400,000.00	12,933,116.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	635,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,189,675.42	49,692,012.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,765,200.00	11,683,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,564,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,265,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,119,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,424,475.42	38,008,212.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,424,475.42	38,008,212.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>71,864,700.00</u>	<u>7,086,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	71,864,700.00	7,086,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,864,700.00	7,086,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	71,864,700.00	7,086,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,864,700.00	7,086,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-71,864,700.00</u>	<u>-7,086,000.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Легрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	193,477,708.66	1,685,927,156.74	00.00	1,879,404,865.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	193,477,708.66	1,685,927,156.74	00.00	1,879,404,865.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	45,397,908.80	00.00	45,397,908.80
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	193,477,708.66	1,731,325,065.54	00.00	1,924,802,774.20
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	193,477,708.66	1,731,325,065.54	00.00	1,924,802,774.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	193,477,708.66	1,731,325,065.54	00.00	1,924,802,774.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	77,768,000.00	00.00	00.00	00.00	77,768,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-89,665,069.16	00.00	-89,665,069.16
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,768,000.00	193,477,708.66	1,641,659,996.38	00.00	1,912,905,705.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	488,619,400.00	382,583,887.59	106,035,512.41	78.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,619,400.00	382,583,887.59	106,035,512.41	78.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,054,600.00	370,900,087.59	104,154,512.41	78.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,803,300.00	218,407,817.52	41,395,482.48	84.1
210101	Үндсэн цалин	237,058,300.00	164,103,219.52	72,955,080.48	69.2
210102	Нэмэгдэл	00.00	26,617,190.00	-26,617,190.00	
210104	Урамшуулал	00.00	22,730,594.00	-22,730,594.00	
210105	Гэрээт ажлын хөлс	22,745,000.00	4,956,814.00	17,788,186.00	21.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,786,900.00	26,623,999.18	7,162,900.82	78.8
210201	Тэтгэврийн даатгал	24,513,700.00	17,966,954.22	6,546,745.78	73.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,318,300.00	2,206,193.86	112,106.14	95.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,854,600.00	1,735,835.09	118,764.91	93.6
210204	Ажилгүйдлийн даатгал	463,700.00	429,358.77	34,341.23	92.6
210205	Эрүүл мэндийн даатгал	4,636,600.00	4,285,657.24	350,942.76	92.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,300,000.00	21,003,754.89	7,296,245.11	74.2
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	7,958,294.89	4,041,705.11	66.3
210302	Түлш, халаалт	12,000,000.00	11,997,500.00	2,500.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,300,000.00	1,047,960.00	3,252,040.00	24.4
2104	Хангамж, бараа материалын зардал	39,352,400.00	39,341,400.00	11,000.00	100.0
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	22,500,000.00	22,500,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	3,989,000.00	11,000.00	99.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,852,400.00	6,852,400.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,695,500.00	22,967,050.00	2,728,450.00	89.4
210604	Урсгал засвар	25,695,500.00	22,967,050.00	2,728,450.00	89.4
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	2,462,000.00	1,538,000.00	61.6
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	2,462,000.00	1,538,000.00	61.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,476,500.00	25,105,950.00	31,370,550.00	44.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,676,500.00	22,393,000.00	31,283,500.00	41.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	550,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	412,950.00	87,050.00	82.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	450,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	300,000.00	300,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	600,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	400,000.00	400,000.00	0.00	100.0

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27640000.00	14988116.00	12,651,884.00	54.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,640,000.00	14,353,116.00	8,286,884.00	63.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	635,000.00	4,365,000.00	12.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13564800.00	11683800.00	1,881,000.00	86.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,564,800.00	11,683,800.00	1,881,000.00	86.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,564,800.00	10,564,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,119,000.00	1,881,000.00	37.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	488,619,400.00	382,583,887.59	106,035,512.41	78.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	488,619,400.00	382,583,887.59	106,035,512.41	78.3
132001	Орон нутгийн төсвөөс	488,619,400.00	382,583,887.59	106,035,512.41	78.3
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		20,942,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		20,942,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		20,942,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,400,000.00
210101	Үндсэн цалин		2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		8,478,850.00
210401	Бичиг хэрэг		3,127,000.00
210402	Тээвэр, шатахуун		4,577,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		574,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,873,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,873,000.00
2107	Томилолт, зочны зардал		140,000.00
210702	Дотоод албан томилолт		140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,050,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,050,950.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		20942800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		20,942,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,867,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,970,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		105,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. Тус байгууллага нь 2022 онд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Иргэдэд үзүүлэх үйлчилгээ, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцон гаргах
- Ард иргэдэд чиглэсэн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилт
- Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны талаар байгууллагын стратеги зорилт
- Эдийн засаг, төсөв санхүү, орлого татвар, худалдан авах ажиллагааны талаар байгууллагын стратегийн зорилт
- Нийгмийн халамж, иргэний бүртгэл, нийгмийн даатгалын талаар байгууллагын стратеги

Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах зэрэг зорилтуудыг давьж хэрэгжүүлэн ажилласан байна..

Ажлын албаны дарга нь Хатгал тосгоны захирагчтай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 83.3 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Захирагчийн 2022 оны 09 сарын 30 өдрийн А/102 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан цаг ашиглалт, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн шууд захирагч буюу ажлын албаны дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,897.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага			
Бараа материал	64,189.8	95,763.9	31,599.1
Үндсэн хөрөнгө	1,860,612.9	1,817,141.8	-43,471.2
Нийт хөрөнгө	1,924,802.8	1,912,905.7	-11,897.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	77,768.0	77,768.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,924,802.8	1,912,905.7	-11,897.1

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, эздийн өмчийн дүн нэмэгдэж, үндсэн хөрөнгө буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Бараа материалын дансны үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь түлш шатах тослох материалын үлдэгдэл нэмэгдсэн, бусад хангамжийн материалын дансанд 18,008.5 мянган төгрөгийн бараа материал нэмж бүртгэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 13,526.0 мянган төгрөгийн урсгал засварын материалыг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.
2. Үндсэн хөрөнгө дансанд байгууллагын эзэмшлийн байдаг 6 газрыг 77,768.0 мянган төгрөгөөр үнэлж орлогод авсан, хөрөнгө оруулалтаар хийгдсэн 12,097.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл зэргийг бүртгэсэн байна. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь тайлант онд 144,479.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна
3. Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/ нэмэгдсэн шалтгаан нь 77,678.0 мянган төгрөгийн 6 газрыг бүртгэлд авч тайланд тусгасантай холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 637,132.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн

байна. Төсвийн төслийн саналаас 209,792.7 мянган төгрөгийн төсвийг хасаж нийт 427,339.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 65,027.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд урсгал засварын зардалд 19,000.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 4,500.0 мянган төгрөг, байр ашиглалтын зардалд 8,000.0 мянган төгрөг цалин урамшууллын зардалд 24,000.0 мянган төгрөг нэмж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 492,367.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 420,592.1 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 68,027.3 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 382,583.9 мянган төгрөг буюу 78.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 20,394.7 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 17,613.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан, төсвөөс авах санхүүжилтийг бүрэн олгоогүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	451,942.9	363,521.0	88,421.9	96.3
2	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх	36,676.5	19,062.9	17,613.7	52.0
	Дүн	488,619.4	382,583.9	106,035.6	78.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 2,670.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хамтарсан багийн дэмжлэгт 300.0 мянган төгрөг олгосон бөгөөд цахим тендерийн бичиг баримтын үнэ 105.0 мянган төгрөг, мөсний баярын зөөврийн нойлын зардалд 5,661.0 мянган төгрөг, мөсний баярын санхүүжилтэд 8,000.0 мянган төгрөг, сонгуулийн зардлын санхүүжилтэд 9,867.0 мянган төгрөг, нийт 20,837.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Хагас жилийн мал тооллогын урамшууллын зардалд 2,400.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 8,478.8 төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 2,873.0 мянган төгрөг, томилолтын зардалд 140.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 7,050.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/82 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 10,105.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,578.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн.

Горим сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илрээгүй. Тайлант онд 68,027.3 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан хэдий ч төсвийн хэмнэлт гарган ажиллаж 38,008.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нийт 678.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 678.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар хэрэгжилтийг дахин тооцож үзэхэд төлбөрийн актыг бүрэн барагдуулж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 126,600.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	126,600.0	2	126,600.0	100
Нийт дүн	2	126,600.0	2	126,600.0	100

Өмнөх онд акт, албан шаардлага өгөөгүй бөгөөд 126,600.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 58,298.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 678.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Зөрчилтэй асуудал илрээгүй тул ямар нэгэн зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Завсрын аудитын зөрчил												
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	2	678.6	1	678.6			1					
Дүн	2	678.6	1	678.6			1					

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	3	58,298.3			3	58,298.3	3	58,298.3				
Дүн	3	58,298.3			3	58,298.3	3	58,298.3				

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 БАТАЛГААЖУУЛСАН:
 АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО: